



ТЕНДЕРИЙН АЖЛЫН ДААЛГАВАР, ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2023.12.14.

Монгол улсын Засгийн газрын 2023 оны 297 дугаар тогтоолоор баталсан төлөвлөгөөний дагуу аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 10 дугаар сарын 16-ний өдрийн 197 дугаар тогтоолоор аймгийн өвс, тэжээлийн аюулгүйн нөөц бүрдүүлэх зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангаас шийдвэрлэсний дагуу 1.100.0 /нэг тэрбум нэг зуун мянган/ төгрөгт тэжээл худалдан авах тендерийн ажлын даалгавар. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын 2023 оны А/432 тоот захирамжийн дагуу 1.100.0 тэрбум төгрөгт малын хорголжин тэжээл худалдан авахаар тендер зарлана.

2. Хорголжин тэжээл нь 2023 онд үйлдвэрлэгдсэн, 50 кг-аар савлагдсан, MNS-1077-2008 стандартын шаардлага хангасан, нэмэгдэл тэжээлийн физик, хими, биологи, аюулгүйг үзүүлэлтийг бүрэн хангасан, лабораторийн шинжилгээтэй байна.

3. Хорголжин тэжээл 50 кг-р савлагдсан 1414 тонноос багагүй байна.

4. Тохирлын гэрчилгээтэй байх.

5. Сүүлийн 3 жилийн хугацаанд тендерт оролцож байсан буюу туслан гүйцэтгэгч малын тэжээл нийлүүлж байсан туршлагатай байх.

6. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт авсан.

7. Сүүлийн 3 жилд татварын өргүй.

8. Тэжээлийг Улсын нөөцийн салбарын Өлгий нөөцийн цэг болон сумуудад тээвэрлэн хүргэх, буулгах, хураах зардлыг тендер авсан аж ахуйн нэгж хариуцна.

9. Нийлүүлэх бүтээгдэхүүн нь гарал үүслийн гэрчилгээтэй байна. /ОХУ-аас импортолсон нөхцөлд малын тэжээл нь холбогдох бичиг баримттай, импортын гэрчилгээтэй байна.

Ажлын даалгавар боловсруулсан: Аймгийн ЗДТГ-ын ХБТХО-ийн
хэлтсийн мэргэжилтэн *Д.Роза* Д.Роза

БАТЛАВ
ЗАСАГ ДАРГА *Жасмин* А.КАМЕЛИЯТ



Аймгийн өвс, тэжээлийн нөөц бүрдүүлэх ажил

Багцын дугаар	Хүргэх эцсийн цэг	Тоо хэмжээ /шуудай/	Төсөвт өртөг
1-р багц	Өлгий, Алтанцөгц, Баяннуур	5 161	197353000
2-р багц	Бугат, Булган, Буянт, Алтай	6 858	267462000
3-р багц	Дэлүүн, Ногооннуур, Толбо,	7 161	279279000
4-р багц	Улаанхус, Цэнгэл, Сагсай /Даян баг/	9 118	355602000
	Нийт дүн	28 298	1099696000